

**“Монгол-Хятадын мөнгө санхүүгийн  
хамтын ажиллагаа” анхдугаар форум дээр  
эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд  
О. Чулуунбатын хэлсэн үг**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Юуны өмнө маш сонирхолтой цаг үеэ олсон форум зохион байгуулж байгаа Шинжлэх ухааны академи, Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-ын Санхүү эдийн засгийн төв их сургуульд гүн талархал илэрхийлж байна. Уг Форумыг дэмжиж ажилласан Монгол банк, Монголын Хөрөнгийн бирж, Худалдаа хөгжлийн банкинд талархал илэрхийлье.

Монгол, Хятад бол хөрш орнууд, натурал худалдаачид худалдаа наймаа хийж, хамтран ажиллаж, амьдарч байгаа хоёр орон. Хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалт дээр суурилсан банк санхүүгийн харилцаа нь хамгийн ил тод, орчин үеийн шаардлагыг хангасан байх ёстой гэж үзэж байна. Өнөөдрийн байдлаар Хятад улс бол Монголын хамгийн том худалдааны түнш болоод байгаа ба Монгол улс 9 гаруй млрд долларын худалдаа хийж байгаагаас 6 гаруй млрд-ийг нь Хятад улстай хийж байгаа нь манай улсын нийт худалдааны 60 гаруй хувийг эзэлж байна. Мөн Хятад улсаас Монгол улсад 6 млрд гаруй долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Энэ хоёр тооноос үндэслээд харахад Монгол, Хятадын хооронд орчин үеийн шаардлагыг хангасан санхүүгийн хамтын ажиллагаа өрнүүлэх шаардлагатай байна. Монгол-Хятадын санхүүгийн харилцаа энэ шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх талаар та бүхэн анхаарлаа хандуулан хэлэлцэж, дутагдалтай тал ба боловсронгуй болгох арга замаа ярилцах байх. Нэг сар гаруйн өмнө БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол улсад айлчлахдаа гурван том салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхээр тохиролцсоны нэг нь

санхүүгийн хамтын ажиллагаа юм. Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн харилцааг дагаад санхүүгийн хамтын ажиллагаа явагдаж байгаа ч энэ нь шаардлага хангахгүй байна. Өнөөдөр санхүүгийн хамтын ажиллагаа нь банк хоорондын хамтын ажиллагаа, хувийн арилжааны банкнуудын санаачлагад үндэслэж байна. Хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааг мөн сайн өрнүүлж чадахгүй байна. Монголын Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа жигдрээгүй, Хятадын хөрөнгийн зах зээл гадаадын хөрөнгө оруулагчдад хаалттай байдгаас шалтгаалан хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааг өрнүүлж чадахгүй байна. Даатгалын салбарын хамтын ажиллагаа ч өнөөгийн худалдаа, хөрөнгө оруулалтын шаардлагыг хангаж чадахгүй байна. Засгийн газрын хэмжээнд хоёр орны санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өрнүүлэх талаар идэвхитэй арга хэмжээнүүд авч байгаа ба үүний нэг тод жишээ нь хоёр төв банкны свопын үйл ажиллагаа юм. Монгол улс Хятад улстай хийж буй санхүүгийн салбарын хамтын ажиллагаа одоогоор ийм байдалтай байна. Банк санхүүгийн харилцаа, хамтын ажиллагааг яаж боловсронгуй болгох сайжруулах, энэ хамтын ажиллагаанаас Монгол улс ямар үр ашиг хүртэх, Хятадын зах зээлд ямар дэмжлэг үзүүлж болох, хоёр талдаа харилцан ашигтай байх талаар энэ форум гол анхаарлаа хандуулах байх гэж бодож байна.

Өнөөдрийн арга хэмжээнд манай хоёр орны санхүүгийн хамтын ажиллагааг тодорхойлох гол байгууллагуудын төлөөлөл, худалдааны компанийн төлөөллүүд, даатгалын салбарын төлөөллүүд ирсэнд баяртай байна.

Та бүхний хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье !